

Эм Си Эс Кока Кола төслийн өргөтгөл

Улс: Монгол

Төслийн дугаар: 47897

Бизнесийн салбар: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

Төрөл: Хувийн

Товлосон хурал болох өдөр: 19.09.2015

Төлөв: Зээлийн хорооны дунд шатны хурлаас батлагдсан, эцсийн шатны хурлаар орох гэж байгаа

Төслийн хураангуй баримт бичиг нээлттэй болсон өдөр: 14.08.2015

Танилцуулга:

ЕСБХБ нь 30 сая ам.доллар хүртэлх урт хугацааны зээлийг Эм-Си-Эс Кока –Кола компанид (“Компани” эсвэл “MCS CC”) компаний хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг санхүүжүүлэх болон компаний санхүүгийн тайланг сайжруулах зориулалтаар олгохоор судалж байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн шилэн савлагаа болон халуун савлах шугамын хөрөнгө оруулалтууд багтаж байгаа болно.

Төслийн эдийн засгийн шилжилтийн явцад үзүүлэх нөлөө

Төслийн хэрэгжүүлсэнээр хөдөө орон нутгийн алслагдсан бүс нутагт борлуулалтын түгээлтийг нэмэгдүүлэх замаар зах зээлийг тэлэх, эрчим хүчний үр ашгийг сайжруулах замаар компанийн засаглал, бизнес удирдан явуулах стандартыг тогтооход нөлөө үзүүлнэ.

Харилцагч

Эм-Си-Эс Кока –Кола нь Монголын тэргүүлэгч ус, ундаа үйлдвэрлэгчдийн нэг бөгөөд харилцаа холбоо, ноос, ноолуур, барилга, уул уурхай зэрэг олон салбар хамарсан үйл ажиллагаа эрхэлдэг Монголын хамгийн том бизнесийн бүлгүүдийн нэг болох Эм-Си-Эс Холдинг компаний охин компани юм.

ЕСБХБ-ны санхүүжилт

ЕСБХБ нь 30 сая ам.доллар хүртэлх зээлийг олон төрлийн валютаар олгоно.

Төслийн зардал

Нийт 37 сая ам.доллар

Төслийн байгаль орчин, нийгмийн ангилал, учирч болох эрсдэл нөлөөллүүд болон түүнээс сэргийлэх нь

Төсөл нь ЕСБХБ-ны 2014 оны журмын дагуу Б зэрэглэлийн нөлөөлөлтэй гэж тодорхойлогдсон. Үйлдвэрлэлийн шилэн савлагаа болон халуун савлагааны хөрөнгө

оруулалтыг хийснээр учирч болох байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны эрсдэлүүдийг харилцагч компани сайн ойлгож байгаа бөгөөд эдгээр эрсдлүүдийг одоогийн удирдлагын систем болон нөөц бололцоогоо ашиглан эрсдэлийг удирдах боломжтой юм. Банкны Байгаль орчины газрын хийсэн газар дээрх шалгалт болон ажилтнуудтай хийсэн уулзалтуудын дүнд төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдлүүд нь их биш бөгөөд өнөөг хүртэл хангалттай удирдагдаж ирсэнийг харж болно. Үйлдлэрлэлийн байр, орчин нь Кока Кола компаний толгой компаний зүгээс гаргасан удирдамжын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд харилцагч нь байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанар зэргийг хамарсан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон төрлийн системүүдийг хэрэгжүүлж байгаа болно. Одоо хийх гэж буй хөрөнгө оруулалтуудад том хэмжээний зай талбай шаардагдахгүй бөгөөд цаашдаа төслийн хэрэгжүүлэлтийн явцад жил бүр ус цахилгааны хэрэглээ гэх мэт нөөц ашиглалтын мэдээ тайланг жил бүр гаргаж өгч байх юм. Дээр дурдсан төслийн эрсдлийн удирдлага нь компаний хувьд сайн хийгдэж байгаа тул байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө гаргаж ажиллах шаардлагагүй болно.

Техникийн хамтын ажиллагаа

Байхгүй.

Холбоо барих

Хатагтай Цэдэндамбын Хандаа

Эм-Си-Эс Кока –Кола компаний Санхүү эрхэлсэн захирал

Хаяг: Гачууртын зам 104, Амгалан 13260, БЗ дүүрэг, 10 дугаар хороо, Улаанбаатар хот, Монгол улс.

Утас: +976-70165555 гар утас: +976-88117501 И-мэйл: khandaa.ts@mcscoacola.mn

Бизнесийн боломж:

Бизнесийн боломж, ханган нийлүүлэлттэй холбоотой асуудлаар харилцагч компанитай шууд холбогдоно уу.

Ерөнхий мэдээллийн лавлагаа

ЕСБХБ-ны төслийн ханган нийлүүлэлттэй холбоогүй ерөнхий лавлагааг:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

И-мэйл: projectenquiries@ebrd.com

Олон нийтэд мэдээлэх бодлого

Олон нийтэд мэдээлэх бодлого нь ЕСБХБ хэрхэн мэдээллийг нээлттэй болгох , хэрхэн оролцогч талуудтай зөвлөлдөж түүний стратеги , бодлого, үйл ажиллагааны талаарх илүү сайн ойлголттой болох зэргийг тодорхойлдог.

Төслийн санал гомдлын механизм

ЕСБХБ нь банкны санхүүжүүлсэн төсөлтэй холбоотой учирсан хохирол болон учирч болзошгүй хохиролтой холбоотойгоор төслийн санал гомдол механизм (PCM) байгуулсан билээ. Энэ механизмын хүрээнд төсөлтэй холбоотой хөндлөнгийн дүн шинжилгээ хийлгэхээр нэг буюу түүнээс дээш хувь хүн эсвэл байгууллагууд гомдол гаргах боломжтой юм.

Төслийн санал гомдлын механизмыг зохицуулах журмууд | Орос хэл дээрх хувилбар

Төслийн гомдлын механизмын дагуу аливаа гомдол санал нь ЕСБХБ-ны сүүлчийн санхүүжилтаас хойш 12 сарын дотор гаргасан байх ёстой. Хэрэв та хэдий хугацаанд гомдол гаргаж болох талаар эргэлзэж байгаа бол гомдол санал хүлээн авах ажилтантай (pcm@ebrd.com) эсвэл холбогдох ЕСБХБ-ны суурин төлөөлөгчийн газартай холбоо барьж болно тусламж авч болно.